



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 09 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар А/181

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 279 дүгээр зүйлийн 279.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх журам”-ыг нэгдүгээр, “Шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдгийн загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Шийдвэр гүйцэтгэх алба / дэд хурандаа С.Батбямба/-нд үүрэг болгосугай.

3. Энэ тушаалыг гарсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ц.АМГАЛАНБАЯР

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ерөнхий газрын даргын 2017
оны 09 дүгээр сарын 12-ны
өдрийн А/181 дүгээр
тушаалын хавсралт

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХУВИЙН ДУГААР ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх, олгох, нэгдсэн бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх олгосон ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгч /цаашид “шийдвэр гүйцэтгэгч” гэх/ нь хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэнэ.

Хоёр.Шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг

2.1.Шийдвэр гүйцэтгэгч “Шийдвэр гүйцэтгэгч” гэсэн бичээс бүхий, хувийн дугаарыг араб тоогоор илэрхийлсэн 30 мм диаметртэй тэмдгийг, ахлах шийдвэр гүйцэтгэгч “Ахлах шийдвэр гүйцэтгэгч” гэсэн бичээс бүхий, хувийн дугаарыг араб тоогоорх илэрхийлсэн 40х20мм харьцаатай тэмдэг хэрэглэнэ.

2.2.Ахлах болон шийдвэр гүйцэтгэгчид нэгдсэн бүртгэлийн дугаарыг үндэслэн хувийн дугаар бүхий тэмдэг олгоно.

Гурав.Хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх

3.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад үйлдэгдэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэгч хувийн тэмдэг дарж баталгаажуулна.

3.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч хувийн дугаартай тэмдгийг энэ журмын 3.1-т заасан ажиллагаа болон шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, шаардлага биелүүлээгүй гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага тооцох ажиллагаанд хэрэглэнэ.

3.3.Шийдвэр гүйцэтгэгч хувийн дугаартай тэмдгийг гарын үсэг зурсан хэсгийг оролцуулж бүрэн, тод, тэгш дарна. Тэмдэг дутуу дарагдсан тохиолдолд дахин дарж, гарын үсэг зурж баталгаажуулна.

Дөрөв.Хувийн дугаар бүхий тэмдэг олгох, нэгдсэн бүртгэл хөтлөх

4.1.Шийдвэр гүйцэтгэгчийн тэмдгийн дугаар олгох, нэгдсэн бүртгэл хөтлөх ажиллагааг Шийдвэр гүйцэтгэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хамтран хэрэгжүүлнэ.

4.2.Шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг хийлгэх зөвшөөрлийг энэ журмын 4.1-т заасан алба өгч, холбогдох зардлыг тухайн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс хариуцна.

4.3.Шийдвэр гүйцэтгэгчийг тойрог хооронд сэлгэн ажиллуулах, шилжүүлэн томилох тохиолдолд тэмдгийн дугаар өөрчлөгдөхгүй ба ажиллах хугацаандаа хувийн дугаартай нэг тэмдэг хэрэглэнэ.

4.4.Шийдвэр гүйцэтгэгчийн тэмдгийн дугаарыг давхардуулан олгохыг хориглоно.

4.5.Хувийн дугаар бүхий тэмдгийн бүрэн бүтэн байдлыг тухайн шийдвэр гүйцэтгэгч хариуцна.

Тав.Хувийн дугаар бүхий тэмдэгийг хүчингүйд тооцох, хяналт тавих

5.1.Шийдвэр гүйцэтгэгч ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд хувийн дугаар бүхий тэмдгийг тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга хурааж авна.

5.2.Хувийн дугаар бүхий тэмдгийг хураан авсан тохиолдолд тэмдэглэл үйлдэж, шийдвэр гүйцэтгэгчигчийн тэмдгийн хамт Шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлнэ.

5.3.Энэ журмын 5.2-т заасан үндэслэлээр ирүүлсэн тэмдгийг хүчингүйд тооцон устгаж, нэгдсэн бүртгэлд тусгайлан тэмдэглэнэ.

5.4.Хувийн дугаар бүхий тэмдгийг ашиглах боломжгүй болсон, үрэгдүүлсэн тохиолдолд тухайн нэгж ажлын 3 хоногт багтаан тэмдэг хэрэглэх зөвшөөрөл олгосон албанд мэдэгдэж, энэ журмын 4.2-т заасан арга хэмжээг авна.

5.5.Энэ журмын 4.1-т заасан алба нь хагас жил тутам шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдгийн үзлэг, тооллого хийж хяналт тавина.

Зургаа.Хориглох зүйл

6.1.Хувийн дугаар бүхий тэмдгийг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэхэд дараах зүйлсийг хориглоно.

6.1.1.хувийн дугаар бүхий тэмдгийг хууль бус үйл ажиллагаанд ашиглах;

6.1.2.бусдад дамжуулах, ашиглуулах, барьцаанд тавих, худалдан борлуулах;

6.1.3.шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад бусдын хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх;

6.1.4.батлагдсан загвар, хийцийг засварлах өөрчлөх;

6.1.5.дур мэдэн зөвшөөрөлгүйгээр захиалах.

Долоо.Хүлээлгэх хариуцлага

7.1.Энэ журмыг зөрчсөн үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол тухайн гэм буруутай албан тушаалтанд хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл ногдуулна.

7.2.Хувийн дугаар бүхий тэмдгийг хүндэтгэн үзэх шалтгаангүй гэсэн, үрэгдүүлсэн үйлдэл нь энэ журмын 7.1-т заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.